



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 52 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/670 дугаар захирамжаар Баянхонгор аймгийн Баянхонгор суманд "Номгон Оюу Авто Бирж" ХХК-ийн хөрөнгөөр барьж байгуулсан автобуудлын барилгыг шилжүүлэн авахыг "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзонд зөвшөөрсүгэй.

2. Автобуудлын барилгыг шилжүүлэн авахтай холбоотой хөрөнгийг "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авч ажиллахыг захирал Б.Гүрсоронзонд даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Хүвч:
0000025
Хянасан